

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөхөөр ажиллах орчуулагч мэргэжилтэн шалгаруулах тухай

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газар ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөхөөр ажиллах орчуулагч мэргэжилтэнг гэрээт ажилтнаар сонгон шалгаруулна.

Тавигдах шаардлага

- Дээд боловсролтой, бакалаврын зэрэгтэй
- Хүний нөөцийн менежер, эдийн засагч, бизнесийн удирдлага, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хөдөлмөрийн эдийн засагч мэргэжилтэй байвал илүү сайн
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх чиглэлээр ажиллаж байсан туршлагатай эсвэл хөдөлмөр эрхлэлтийн салбарт 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай, цаашид хөдөлмөр эрхлэлтийн салбарт тогтвортой ажиллах хүсэл сонирхолтой хөдөлмөрийн насны иргэн байх
- Тусгай шаардлага: мэргэжлийн англи хэлний эсвэл герман хэлний мэдлэгтэй бичгийн болон аман орчуулга хийх чадвартай байх
- Харилцааны ур чадвар: багаар ажиллах, ажил үүргийг ойлгох чадвар, зөвлөгөө өгөх чадвартай байх

Шалгуурлалтанд оролцох хүсэлтэй иргэн доорхи материалыг бүрдүүлнэ:

- Дээд боловсролын дипломын хуулбар
- Хувийн анкет, ажлын туршлагаа нотолсон тодорхойлолт

Шалгаруулалтын материалыг 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийг дуустал хугацаанд ХХҮЕГазрын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Батцэцэг хүлээн авна.

Шалгаруулалтыг материал хүлээн авсны дараа 2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр сонгон шалгаруулалтын ярилцлагыг материал хүлээн авсан дараалалаар хийнэ.

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө

Лавлах утас : 70141507